

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ: ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

*Л.Амгаланбаатар, Х.Норовсүрэн, Б.Жавхлан*

### АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Эдүгээ Монгол Улсад 880 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагийн<sup>1</sup> 318 хуульд хүний эрхэд сөрөг нөлөө бүхий 810 заалт байна. Үүний шалтгаан нь хуулийн төсөл боловсруулах явцад эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэд, нийгмийн тодорхой бүлгээс санал авдаггүй, хүний эрхийн байгууллага, судлаачдын санал, зөвлөмжийг харгалзан үзэж, хуулийн төсөлд тусгадаггүйтэй холбоотой байна.<sup>2</sup>

Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) жил бүр эрхлэн гаргадаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлдээ хууль тогтоомжийг хүний эрхийн үндсэн шаардлагад нийцүүлж боловсруулах зөвлөмжийг удаа дараа өгч байжээ. Тухайлбал, ХЭҮК-ийн 2023 онд гаргасан 22 дахь илтгэлд “...илтгэлд тусгасан долоон үндсэн чиглэлийг тусгаж, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний шаардлагад нийцүүлэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн найруулах”<sup>3</sup> гэсэн зөвлөмж өгсөн нь тус хуульд хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэл бүхий тодорхой зохицуулалт байгааг илтгэж байна.

Хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа бүрдүүлэх үндсэн зорилготой хууль тогтоомж өөрөө ийнхүү

хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэл дагуулж буй тухай дээрх дүгнэлт нь хууль тогтоомжийн төсөл, түүнийг боловсруулах үйл явцад хуулиар тогтоосон олон нийтийн оролцоо, судалгаа шинжилгээ хийх шаардлагыг хэрэгжүүлэхгүй, тэр тусмаа хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ зохих ёсоор хийгдэхгүй байгааг илтгэж байна. Энэ нь нэг талаас хууль тогтоомжийн төсөлд хийх судалгааны аргачлалд хүний эрхийн нөлөөллийг үнэлэх удирдамж, арга зүй төдийлөн оновчтой тусаагүй байгаатай холбоотой.

Иймд хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх хууль зүйн шаардлага, түүний хэрэгжилтийг үнэлэх зорилгоор энэхүү бодлогын шинжилгээг хийлээ. Энэ хүрээнд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэгдсэн бөгөөд [www.lawforum.parliament.mn](http://www.lawforum.parliament.mn), [www.d.parliament.mn](http://www.d.parliament.mn) цахим хуудаст нийтлэгдсэн нийт 135 хуулийн төсөлд (Хавсралт 4) хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийсэн байдлыг тоон болон чанарын аргаар үнэлэв.

<sup>1</sup> [Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем], [Нэвтрэх холбоос: <https://legalinfo.mn/mn>], [Сүүлд нэвтэрсэн огноо: 2024.09.21]

<sup>2</sup> [О.Мөнхсайхан, Р.Очирбал], [2021 он], [Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл], [478 тал], [Улаанбаатар хот]

<sup>3</sup> [Хүний эрхийн үндэсний комисс], [2023 он], [Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл], [576 тал] [Улаанбаатар хот]

## ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрхийг эдлэх ба энэхүү эрхийн хүрээ хязгаар, хуулийн төслийн агуулга, хэлбэр, үйл явцад тавих шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулиар нарийвчлан зохицуулж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг хангах, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх арга зам нь хуулийн төсөл боловсруулахад тавих шаардлагуудыг бүрэн хангах явдал юм. Ялангуяа, хуулийн төслийг судалгаа шинжилгээнд суурилан боловсруулах үндсэн зарчмыг<sup>4</sup> бүрэн хэрэгжүүлэх, үүний дотор хүний эрхийн нөлөөллийг судлан тогтоох нь нэн чухал.

Уг зарчмыг хэрэгжүүлэх үйл явцыг Хууль тогтоомжийн тухай хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг.<sup>5</sup> Энэ хүрээнд дараах дөрвөн төрлийн судалгаа хийхийг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан байдаг.

- Шинэ хууль гаргах бол хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах,
- Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад түүний хэрэгжилт, үр дагаврыг үнэлэх,
- Дээрх судалгааны үндсэн дээр боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд үр нөлөөний үнэлгээ хийх,
- Хууль хэрэгжүүлэхэд зайлшгүй гарах зардлыг тооцох.

Эхний хоёр судалгааг хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулахаас өмнө (суурь

судалгаа) ба харин үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хуулийн төсөл боловсруулсны дараа хийнэ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу Засгийн газар 2016 онд судалгааны нарийвчилсан аргачлалуудыг батлан гаргажээ.<sup>6</sup> Эдгээр судалгааны судлах асуудал болон аргачлалд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хэрхэн тусгагдсаныг авч үзье.

### Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа

Энэхүү судалгааны агуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэхийг судлах;
- Тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох;
- Тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох;
- Зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох;
- Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтыг судлах.

<sup>4</sup> Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт.

<sup>5</sup> Судалгаа шинжилгээ нь хууль тогтоомжийн шинэчлэлийн төлөвлөлтийн нэг үе шат юм. Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийг урьдчилан төлөвлөж, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг боловсруулна. Энэ ажлыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан холбогдох байгууллагуудын саналыг авч нэгтгэх ба санал өгөх байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар анхдагч хууль, шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно.

<sup>6</sup> [Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, Засгийн газрын тогтоол], [Нэвтрэх холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11993>], [Сүүлд нэвтэрсэн огноо: 2024.09.21]

Үүнээс үзэхэд хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ заавал хийх ба шинээр батлан гаргах хууль тогтоомжийн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тогтоосны үндсэн дээр зохицуулалтын хамгийн оновчтой хувилбарыг сонгох учиртай.

Засгийн газраас баталсан уг судалгааны аргачлалд хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийг дараах 5 бүлэгт хамаарах 17 шалгуур асуултын дагуу үнэлэн тодорхойлохоор заажээ. Тодруулбал, зохицуулалтын боломжит хувилбарууд нь хүний эрхийн суурь зарчимд нийцэж байгаа эсэх, хүний эрхийг хязгаарлах эрсдэлтэй эсэх, зохицуулалтын нөлөөлөлд эрх, хууль ашиг сонирхол нь хөндөгдөх талууд болон үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуульд нийцэх эсэхийг тогтооно. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний асуултыг Хавсралт 1-ээс авч үзнэ үү.

Гэхдээ уг аргачлалд дараах асуудал тусаагүй байна. Үүнд:

- Хүний эрхийн нөлөөллийг тогтоох асуултад хариулах удирдамж буюу хариултын үндэслэлийг заавал тайлбарлах, нотлохыг шаардаагүй.
- Хүний эрхийн нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлт байхгүй.
- Хүний эрхийн нөлөөллийг үнэлэхэд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудын оролцоог хэрхэн хангах нь тодорхойгүй.
- Хүний эрхийн үндэсний комисс гэх мэт мэргэжлийн байгууллагын оролцоог хангах, санал дүгнэлт авах шаардлага тусгагдаагүй.

### **Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ**

Тус судалгаа нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгэмд үзүүлж

буй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилготой. Судалгааны агуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх,
- Гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх,
- Цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.

Үүнд хүний эрхийн нөлөөлөл гэж тухайлан дурдаагүй боловч нийгэмд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох агуулга нь түүнийг бүрэлдүүлэгч хүн, тодорхой бүлэгт үзүүлэх нөлөөллийг хамарч байна. Өөрөөр хэлбэл, судалгааны агуулга нь тухайн хууль тогтоомжоос хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг судлан тогтоох шаардлагыг шууд бус утгаар илэрхийлж байна.

Харин Засгийн газрын баталсан судалгааны аргачлалд хүний эрхийн зөрчил, эрсдэлийг үнэлэн тодорхойлох аливаа асуулт ороогүй буюу хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийхийг огт шаардаагүй байна. Тэрчлэн уг аргачлал нь зөвхөн судалгааны хүрээнд сонгон авсан тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхээс бус хуулийн хэрэгжилт, үр нөлөөг бүхэлд нь үнэлж дүгнэх шаардлага тогтоогоогүй.

Судалгаанд хамрагдсан 135 хуулийн төслийн 55 буюу бараг дөрөвний нэг нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл байна. Гэтэл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хийгдэх суурь судалгаа буюу хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээний хүрээнд хүний эрхийн нөлөөллийг судлан тогтоох шаардлага тухайлан хуульчлагдаагүй байна.

График 1. УИХ-д өргөн мэдүүлэгдсэн хуулийн төслийн төрөл (2023.01.01-2024.06.30)



Иймд цаашид уг судалгааны агуулгыг шинэчлэн тогтоож, хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэхийн өмнө тухайн хуулийн хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг заавал нарийвчлан тогтоох шаардлагыг хуульчлах нь зүйтэй.

### Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгаа

Энэхүү судалгааг хуулийн төслийн эх бичвэрийг боловсруулж дууссаны дараа, бүх хуулийн төсөлд (хуулийн төслийн төрлөөс үл хамааран) зайлшгүй хийх ба тухайн төсөлд тусгагдсан зарим тодорхой зохицуулалтын (судалгааны хүрээнд сонгон авсан) практикт хэрэгжих боломж, эерэг, сөрөг үр дагавар, дагалдах хуулиудад орох өөрчлөлт, тэдгээрийн үр нөлөөг тодорхойлох зорилготой.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан судалгааны агуулга:

- Хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх;
- Хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

- Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох;
- Хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх.

Хүний эрхийн нөлөөллийг үнэлэх зохицуулалт нь нэлээд хожуу 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр оржээ. Гэсэн хэдий ч уг заалтыг хэрэгжүүлэх удирдамж, аргачлал, үнэлгээний нарийвчилсан асуулт, шалгуур үзүүлэлт өнөөг хүртэл батлагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, хуульд дээрх нэмэлт, өөрчлөлт орсноос хойш Засгийн газар судалгааны аргачлалыг шинэчлэн батлаагүй байгаа болно. Гэхдээ хуулийн дээрх өөрчлөлтөөс өмнө ч уг судалгааны аргачлалд хүний эрхийн нөлөөллийг тогтооход чиглэсэн ерөнхий асуулга байсан бөгөөд судалгааны хүрээнд сонгон авсан тодорхой заалтуудыг “хүний эрхийг хязгаарласан эсэх” гэсэн ганцхан ерөнхий шалгуураар үнэлж иржээ.

Дээр дурдсанаас үзвэл, хуулийн төсөл боловсруулах хүрээнд хийгдэх зардлын тооцооноос бусад гурван судалгаанд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ ямар нэг түвшинд заавал хийгдэхээр байна. Гэсэн хэдий ч Засгийн газраас баталсан судалгааны аргачлалуудад хуулийн энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх нарийвчилсан удирдамж тусгагдаагүйгээс бүрэн хэрэгжихгүй байна. Ялангуяа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх болон хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны аргачлалуудад хүний эрхийн нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлт огт тусгагдаагүй болно. Иймд одоогоор зөвхөн хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд л хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийгдэж байна.

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛД ХҮНИЙ ЭРХИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЖ БУЙ БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

Өмнө дурдсанчлан, хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд хийгдэх хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ, түүний цар хүрээ нь Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон тухайн төрлийн судалгааны судлах асуудал ба Засгийн газраас баталсан аргачлалаас шууд хамаарна.

Тэрчлэн Хууль тогтоомжийн тухай хуулиар судалгаа шаардахгүй нөхцөлүүдийг бас тодорхойлсон бөгөөд тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 болон 12.3-т үүнд хамаарах 22 нөхцөлийг тодорхойлжээ.<sup>7</sup>

Судалгаанд хамрагдсан 135 хуулийн төслийн 51 нь судалгаа шаардахгүй нөхцөлд хамаарч байгаа тул үлдэх 84 төсөлд холбогдох судалгаа болон хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хэрхэн хийгдсэнийг авч үзэв.

График 2. Өргөн мэдүүлэгдсэн хуулийн төслүүд: Судалгаа хийх шаардлагатай эсэх



Судалгаа хийх шаардлагатай 84 хуулийн төсөлд суурь судалгаа буюу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа болон

хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдэж, тайлан нь олон нийтэд нээлттэй болсон эсэхийг График 3 ба 4-т үзүүлэв.

График 3. Суурь судалгааны тайлан нийтлэгдсэн эсэх



График 4. Суурь судалгааны төрөл



Хууль тогтоомжийн тухай хуулийн судалгааны шаардлагад хамаарах 84 хуулийн төслийн 5-д нь суурь судалгааны тайлан хавсаргагдаагүй байна.

### Хүснэгт 1. Суурь судалгааны тайлангүй хуулийн төслүүд

№	Хууль санаачлагч	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр
1	Монгол Улсын Засгийн газар	2023.01.08	Нэмэлт, өөрчлөлт	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

<sup>7</sup> Судалгаа шаардахгүй онцгой тохиолдлуудыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт тодорхойлсон бөгөөд энэ талаар ННФ-аас эрхлэн гаргадаг Бодлогын асуудал цувралын 49 дэх дугаараас дэлгэрүүлэн үзнэ үү. [Нэвтрэх холбоос: <https://forum.mn/product/434676>].

№	Хууль санаачлагч	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн төрөл	Хуулийн төслийн нэр
2	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Өөрчлөлт оруулах	Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
3	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Нэмэлт, өөрчлөлт	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
4	Монгол Улсын Засгийн газар	2024.04.17	Шинэчилсэн найруулга	Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
5	Монгол Улсын Засгийн газар	2024.04.29	Шинэчилсэн найруулга	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Өргөн мэдүүлэгдсэн хуулийн төслийг байршуулдаг нээлттэй эх сурвалжид дээрх таван төслийн суурь судалгааны тайлан байхгүй тул судалгаа хийсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.<sup>8</sup> Эдгээрээс нэг нь бие даасан хууль биш буюу хуулийн хэрэгжих хугацаа, журмыг нарийвчлан зохицуулдаг “дагаж мөрдөх журмын тухай хууль” болох тул судалгаа хийх шаардлага хамаарахгүй байх магадлалтай. Харин үлдсэн дөрөв нь шинэчилсэн найруулга ба нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байх тул тэдгээрийг боловсруулахаас өмнө хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хэрэгжилт, үр дагаврыг зайлшгүй үнэлж, тайланг нийтлэх шаардлагатай байв. Энэ нь Хууль тогтоомжийн хуулийн 4 дүгээр зүйлд заасан “судалгаа шинжилгээнд үндэслэх”, “ил тод байдлыг хангах” зарчмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Түүнчлэн эдгээрийн дотор Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай зэрэг нийтийн ашиг сонирхол, Үндсэн хуулиар баталгаажсан хүний хөдөлмөрлөх болон бусад эрхэд нөлөө бүхий хуулийн төслүүд байгааг анхаарах нь зүйтэй.


Суурь судалгаа хийгдсэн 79 хуулийн төслийн 37-д нь хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, үлдсэн 42-т нь хууль

тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ тус тус хийгджээ.

Дээр дурдсанчлан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны агуулга, аргачлалд хүний эрхийн үнэлгээний шаардлага тусгагдаагүй тул цаашид дуг үнэлгээний хэрэгжилт, чанарыг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд нарийвчлан авч үзлээ.

### Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийг үнэлсэн байдал

График 5. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийг үнэлгээ хийсэн байдал



■ Хүний эрхийн үнэлгээ хийгээгүй  
■ Хүний эрхийн үнэлгээ хийсэн

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийсэн 37 хуулийн төслийн 31-д нь хүний эрхийн нөлөөллийг үнэлсэн бол 6-д нь хүний эрхийн үнэлгээ хийгдээгүй буюу холбогдох асуултад огт хариулаагүй байна (Хавсралт 2).

<sup>8</sup> www.lawforum.parliament.mn ; www.d.parliament.mn

График 6. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний асуултад хариулсан байдал



Хүний эрхийн үнэлгээний асуултад хариулсан байдлыг авч үзвэл, дээр дурдсан 31 хуулийн төслийн зөвхөн 15-д нь хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний 5 бүлэг, 17 асуултад зохих тайлбартайгаар хариулжээ. Гэсэн хэдий ч тухайн хариултын үндэслэлийг тодорхойлох мэдээ, баримт тайланд тусгагдаагүй тул үнэлгээний чанар, үндэслэл бүхий байдалд дүгнэлт өгөх боломжгүй байв. Тэрчлэн тайлбар нь хэт ерөнхий буюу “хуулийн төсөлд хориглосон зохицуулалт байхгүй”, “хуулийн төсөлд хүний

эрхийг хязгаарласан агуулга байхгүй”, “хүний эрхийг хангаж байгаа” гэх мэтээр хариулсан нь хангалтгүй бөгөөд хүний эрхийн үнэлгээний ач холбогдлыг бууруулж байна. Мөн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайланд бүх асуултын хариултад “Хуулийн төслийн зохицуулалт, агуулга нь энэхүү нөхцөл, ойлголтыг хөнддөөгүй буюу хүрээлэлд хамаарахгүй, тусгайлан авч үзэх шаардлагагүй” гэсэн ганц ижил тайлбар хийсэн байв.

Хүний эрх үнэлгээний асуултад ямар нэг тайлбар, нотолгоогүй “тийм”, “үгүй” гэсэн хариултыг сонгох төдий хариулсан 16 тохиолдлыг Хавсралт 3-аас авч үзнэ үү. Уг 16 тохиолдлоос дор дурдсан 6 тохиолдолд бүх асуултад нэгэн адил зөвхөн “тийм” эсхүл “үгүй” гэж хариулсан нь анхаарал татаж байна. Зүй нь асуулт тус бүрийн агуулгаас хамааран “тийм”, “үгүй” гэсэн хариултын аль тохирохыг сонгох учиртай бөгөөд энэхүү ялгааг гаргаагүй нь хүний эрхийн нөлөөллийн үнэлгээнд ач холбогдол өгч нухацтай хандаагүйг илтгэж байна.

Хүснэгт 2. Хүний эрхийн үнэлгээний бүх асуултад нэг ижил байдлаар хариулснаас шалтгаалан зарим асуултын агуулгад тохироогүй сөрөг утга илэрхийлэгдсэн нь

№	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Хүний эрхийн нөлөөллийг тогтоох асуулт	Хариулт
1	2023.01.16	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд	Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	үгүй
			Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	үгүй
			Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	үгүй
2	2023.06.02	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	үгүй
			Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	үгүй
			Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	үгүй

№	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Хүний эрхийн нөлөөллийг тогтоох асуулт	Хариулт
			Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	үгүй
3	2023.06.02	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	үгүй
			Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	үгүй
			Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	үгүй
4	2024.04.09	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	үгүй
			Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	үгүй
			Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	үгүй
			Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	үгүй
5	2024.04.30	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх гэснээс бусад бүх асуулт	үгүй
6	2024.05.21	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	үгүй
			Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	үгүй
			Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	үгүй
			Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	үгүй



Дээрхээс харвал, бүх асуултад “үгүй” гэж хариулсан тохиолдолд “Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх”, “Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх” гэх зэрэг асуултад “үгүй” гэсэн хариулт өгөгдөх ба энэ нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан олон нийтийн хэлэлцүүлгийн шаардлагыг зөрчсөн, хуулийн төсөл ялгаварлан гадуурхалтын эрсдэл үүсгэх эрсдэлтэй гэсэн сөрөг утгыг илэрхийлж байна. Харин бүх асуултад “тийм” гэж хариулснаар “Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх” гэсэн асуултад ч тийм гэж хариулсан тохиолдол ч байна.

Тэрчлэн 2024 онд өргөн баригдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайланд тусгасан хүний эрхийн үнэлгээний хариулт ба түүний тайлбар нь 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр өргөн мэдүүлэгдсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний хариулттай үг, үсгийн зөрүүгүй адилхан байсан нь анхаарал татаж байна.


### Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний хүрээнд хүний эрхийн нөлөөллийг үнэлсэн байдал

Аливаа хуулийн төслийг боловсруулсны дараа үр нөлөөг нь үнэлэх замаар дахин сайжруулах шаардлагыг Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон. Уг судалгааны аргачлалаар хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэхэд хүний эрхэд үзүүлэх нөлөөг “Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх” гэсэн ганцхан асуултын хүрээнд хэлбэр төдий үнэлж иржээ.

Судалгаа хийх шаардлагатай буюу График

2-т дурдсан 84 хуулийн төслийн 9 төслийн бүрдүүлбэрт үр нөлөөний үнэлгээний тайлан тусгагдаагүй буюу судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй байв.<sup>9</sup>

График 7. Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдсэн эсэх



Дээрх 75 хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлангийн 32 нь дээрх асуултад огт хариулаагүй. Харин үлдсэн 43 нь ямар нэгэн байдлаар хариулсан байх боловч хариулт нь ихэвчлэн “хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй”, “үгүй”, “тусгаагүй”, “шаардлага хангасан” зэрэг гэх мэт ерөнхий байна. Тэрчлэн ийнхүү хариулсан шалтгаан үндэслэлийг тайлбарласан, нотолсон тохиолдол байхгүй нь энэ төрлийн судалгаа мөн л зохих ёсоор хийгдэхгүй байгааг харуулж байна.

График 8. Хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээний хүрээнд хүний эрхийн нөлөөллийг үнэлсэн байдал



<sup>9</sup> www.lawforum.parliament.mn ; www.d.parliament.mn

## КЭЙС СУДАЛГАА

Хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа бүхий 37 хуулийн төслөөс (График 4) УИХ-аар батлагдсан дараах дөрвөн хуулийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч, уг судалгаа болон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний хүрээнд хийгдсэн хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний агуулга, чанарыг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийн оролцоог хангасан байдал, үнэлгээний асуултад хариулсан байдал зэрэг шалгуураар үнэлэхийг зорилоо.

- **Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл (анхдагч хууль)**

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн уг хуулийн төсөл нь 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр УИХ-ын чуулганаар батлагджээ.

Хуулийн төслийн бүрдүүлбэр нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн шаардлагад нийцсэн буюу холбогдох судалгаа, тооцоо бүрэн хийгдсэн байна.

Гэсэн хэдий ч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаанд анхаарвал зохих дараах асуудлууд байна. Үүнд:

- Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй нийгмийн бүлгийг маркетинг зар сурталчилгаа, кино урлаг, дүрс бичлэг, гар урлал, дуу хөгжим, музей, дурсгалт газар зэрэг соёл, урлагийн төрлөөр ангилан 12 бүлэг, 28 дэд бүлэгт хуваан тодорхойлжээ. Хууль санаачлагчийн зүгээс эдгээр бүлгийн төлөөлөл болох 400 хүнийг хамарсан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн форум зохион байгуулж, хуулийн төслийг хэлэлцүүлсэн байна. Тэрчлэн 2022 оны 12 дугаар сараас 2023 оны 1 дүгээр сарын хооронд зохион байгуулагдсан есөн удаагийн хэлэлцүүлэгт соёлын салбарын эрдэмтэн, судлаачид болон соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл болох 73 хүн оролцжээ. Хуулийн төслийн бүрдүүлбэрт дурдсанаар эдгээр хэлэлцүүлгээс гарсан 54 саналын 39 нь

хуулийн төсөлд ямар нэгэн байдлаар тусгалаа олсон байна.

- Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний 17 асуултын хариултыг дийлэнх тохиолдолд тайлбарлаагүй, баримт нотолгоо дурдаагүй байна. Ганцхан “Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх” гэсэн асуултад “Салбарын онцлог нь илүү эмэгтэйчүүд руу чиглэсэн байдаг. Хуулийн зохицуулалт бий болсноор эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт нэмэгдэх боломжтой” гэсэн тайлбар хийсэн байх боловч түүнийг нотлох судалгаа, тоо баримт дурдаагүй. Тэрчлэн хуулийн төсөлд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих тухайлсан зохицуулалт тусгагдаагүй болно.

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн талаар огт дурдаагүй. Энэ нь уг хууль 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө буюу уг судалгааны агуулгад хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний шаардлага тусгагдахаас өмнө өргөн баригдсантай холбоотой байж болох юм.

Тус хуулийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө 2022 оны 12 сарын 01-ний өдөр олон нийтийн санал авахаар цахим орчинд үзэл баримтлал, холбогдох судалгааны тайлангуудын хамт байршуулсан боловч санал өгөх арга зам тодорхойгүй буюу зар мэдээний хэлбэрээр нийтэлжээ.

- **Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай анхдагч хуулийн төсөл**

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 сарын 31-ны өдөр өргөн мэдүүлсэн тус хуулийн төслийг УИХ 2023 оны 12 сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн баталжээ. Тус хууль нь яаралтай горимоор өргөн мэдүүлэгдсэн (Хууль

тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т зааснаар судалгаа хийх шаардлагагүй) боловч хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа хийгдсэн байна. Гэхдээ энэ хүрээнд хүний эрхийн нөлөөллийг тодорхойлсон байдал нь учир дутагдалтай байна. Үүнд:

- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайланд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талууд, нийгмийн бүлгийг тодорхойлоогүй. Хуулийн үйлчлэх хүрээг Улаанбаатар хот хэмээн тодорхойлсон боловч дагалдах хуулиуд, ялангуяа Газрын тухай хуульд тусгагдсан зохицуулалт нь нийт иргэдийн өмчлөх эрхийг хөндөх үр дагавартай. Тодруулбал, тус хуульд туссан нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх, нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар болон такси үйлчилгээнд хязгаарлалт тогтоох зохицуулалт нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний өмчлөх эрхийг хязгаарлах эрсдэлтэй. Гэтэл судалгааны тайланд энэ талаар дурдаагүй, хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний 17 багц асуултад огт хариулаагүй нь судалгаа зохих ёсоор хийгдээгүйг илтгэж байна. Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны аргачлалын дагуу хүний эрхийг хязгаарлах үр дагавар бүхий дээрх заалтуудыг зохицуулалтын өөр ямар хувилбаруудаас яагаад сонгох болсныг заавал тодорхойлох ёстой байв.
- Судалгааны тайланд харин эсрэгээрээ “Энэ агуулгаар энэхүү хуулийг баталснаар хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхийг баталгаажуулахаас гадна эдгээр иргэдийн эдийн засгаас хүртэх алдагдсан боломжийг олгох, хүн ажил хөдөлмөр эрхлэх, бизнес чөлөөтэй эрхлэх эрхийг хангах нөхцөл болно” хэмээн дурджээ.

Ийнхүү суурь судалгаа зохих ёсоор хийгдээгүйгээс гадна хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайланд “тус

хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусаагүй” гэж дүгнэсэн нь анхаарал татаж байна.

Тэрчлэн уг хуулийг нэн яаралтай горимоор өргөн мэдүүлж, баталсан тул олон нийтийн хэлэлцүүлэг, санал авах ажиллагаа хийгдээгүй болно. Энэ мэтээр хүний эрхийг хөндөх, хязгаарлах үр дагавар ихтэй хууль тогтоомж батлагдан гарч байгаа нь холбогдох судалгаа, ялангуяа хүний эрхийн үнэлгээ зохих ёсоор хийгдэхгүй байгаагийн тод жишээ болж байна. Иймд судалгааны аргачлал, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулахын зэрэгцээ яаралтай горим зэрэг судалгаа шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлгийг алгасах нөхцөл бүрдүүлж байгаа зохицуулалтуудыг эргэн харж, нарийвчилсан шаардлага тогтоох замаар хүний эрхийг хязгаарлах эрсдэлтэй хууль тогтоомж батлагдан гарахаас сэргийлэх шаардлагатай.

- **Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл**

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 сарын 08-ны өдөр өргөн мэдүүлснийг УИХ 2023 оны 07 сарын 07-ны өдөр хэлэлцэн баталжээ.

Тус хуулийн холбогдох судалгааны хүрээнд хийгдсэн хүний эрхийн нөлөөллийн үнэлгээнд анхаарвал зохих дараах асуудал байна. Үүнд:

- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайланд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх нийгмийн бүлгүүдийг тэдгээрийн онцлогт тулгуурлан нарийвчлан тодорхойлсон нь сайшаалтай. Үүнд, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, төрийн албан хаагч, хөдөлмөрийн чадвараа түр алдсан иргэн, хорих ял эдэлж буй иргэн, гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг, улсын хил дээр алба хааж буй албан хаагч, түүний гэр бүл, цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэд гэх зэрэг 24 бүлгийг

ангилан тодорхойлжээ. Гэсэн хэдий ч хуулийн төслийг дээрх бүлгүүдэд танилцуулж, санал авсан байдал нь хангалтгүй байна. Хуулийн төслийн бүрдүүлбэрийг харвал, зөвхөн яамд болон Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо зэрэг байгууллагаас санал авчээ. Хуулийн төслийн саналын томьёонд “дээрх байгууллагуудаас нийт 29 санал хүлээн авсны 14 саналыг хуулийн төсөлд тусгасан, эсхүл хуулийн төслийн агуулгад багтсан” хэмээн дурджээ.

- Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний 17 асуултад аргачлалын хүрээнд зөвхөн тийм эсхүл үгүй гэх байдлаар хариулж, зохих тайлбар хийсэн байх боловч түүнийг нотлох тоо, баримт дурдаагүй байна.
- Хууль тогтоомжийн үр нөлөөний үнэлгээнд хүний эрхийн нөлөөллийн талаар огт дурдаагүй.

Хуулийн төслийг иргэдээс санал авах зорилгоор цахим хуудаст байршуулж, 7 санал хүлээн авсан боловч хуулийн төсөлд хэрхэн тусгасан нь тодорхойгүй байна.

- **Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Тус хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 сарын 01-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн нь 2023 оны 07 сарын 07-ны өдөр батлагджээ.

Тус хуулийн төслийн бүрдүүлбэрт үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, холбогдох албан бичгүүд багтсан байна. Дээрх судалгаануудын хүрээнд хийгдсэн хүний эрхийн нөлөөллийн үнэлгээнд анхаарвал зохих зарим асуудал байгааг дурдвал:

- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны тайланд эрх, хууль ёсны

ашиг сонирхол нь хөндөгдөх нийгмийн бүлгийг бизнес эрхлэгч, иргэд, төрийн байгууллага гэсэн байдлаар ерөнхийлөн тодорхойлсон бөгөөд эдгээрээс зөвхөн төрийн байгууллага буюу холбогдох яамдаас санал авсан байна.

- Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний 17 багц асуултад тухайлсан тайлбар, нотолгоогүйгээр бүх хариултад “үгүй” гэж хариулжээ. Ингэхдээ “олон нийтийн болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн оролцоог хангасан эсэх”, “зохицуулалтын арга хэлбэр нь Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмд нийцсэн эсэх”, “хүний эрхийг хамгаалах, дэмжих эсэх” зэрэг асуултад хүртэл “үгүй” гэж хариулсан нь үнэлгээ зохих ёсоор хийгдээгүйг нотолж байна.

### **Хууль тогтоомжийн төслийн хяналт**

Засгийн газраас өргөн мэдүүлж буй хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар чиг үүргийн хүрээнд хянадаг ба УИХ-ын Тамгын газар хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов тогтоолгох албан бичгийг үндэслэн бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянаж, бүрдүүлбэр хангасан тохиолдолд УИХ-ын даргад өргөн мэдүүлдэг.

Судалгаа хийх шаардлагатай 84 хуулийн төслийн 5 нь суурь судалгааны, харин 9 нь үр нөлөөний тайлангүй байгаа нь хуулийн төслийн бүрдүүлбэрт тавих хяналт мөн зохих ёсоор хэрэгжихгүй байгааг илэрхийлж байна. Тэрчлэн хуулийн төслийн баримт бичгийн ил тод байдлын шаардлага, түүнд тавих хяналт огт байхгүйгээс бүрдүүлбэр, түүнд орсон өөрчлөлтийг бүрэн нийтлэхгүй байгааг харуулж байна.

Тэрчлэн дээрх хоёр шатны хяналтын хүрээнд зөвхөн бүрдүүлбэр хангасан байдал буюу холбогдох судалгаа, бусад баримт бичгийн бүрдлийг шалгах аас бус тэдгээрийн агуулга, чанарт үнэлэлт дүгнэлт өгдөггүй байна. Өөрөөр

хэлбэл, зөвхөн хуулийн төслийн агуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шалгуураар хянахаас бус судалгаа, шинжилгээний тайлан, олон нийтийн хэлэлцүүлэг зохих ёсоор, чанартай хийгдсэн эсэхийг авч үздэггүй байна. Энэ нь дээрх судалгааны хүрээнд хуулийн үйлчлэлд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг бүрэн тодорхойлохгүй, оролцоог нь хангахгүй, хүний эрхийн үнэлгээг зохих ёсоор хийхгүй буюу холбогдох асуултад хариулахгүй, эсхүл хэлбэр төдий, баримт нотолгоогүйгээр хариулж байгаагийн шалтгаан болж байна.

Харин Хууль тогтоомжийн тухай хуулийн 2024 оны 05 сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу УИХ-ын Тамгын газар хуулийн төслийн бүрдүүлбэрийн агуулгад дараах хяналт тавих болжээ.

- Хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;
- Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан эсэх;
- Хуулийн төслийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгаанд үндэслэн боловсруулсан эсэх;
- УИХ-ын тухай хуульд заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарыг хангасан эсэх;
- Зардлын тооцооллыг холбогдох журам, зааврын дагуу боловсруулсан эсэх.

Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт агуулгын хяналт тавих хүрээнд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн “Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд хүний эрхийн нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал батлах тухай” 187 тоот захирамж батлагдсан болно.

Дээрх аргачлалд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан хүний үндсэн эрхэд үзүүлэх нөлөөллийг нийт 71 шалгуур

асуултаар нарийвчлан үнэлэх зохицуулалт тусгагдсан нь сайшаалтай. Түүнчлэн Улсын Их Хурлын даргын 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 77 дугаар захирамжаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журам” батлагджээ. Гэхдээ уг журам нь УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд баримтлах дотоод журам байх бөгөөд түүний дагуу хийгдсэн хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний дүгнэлт нь хараахан олон нийтэд ил тод бус байх тул энэхүү судалгааны хүрээнд хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байв.

### Дүгнэлт

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хийгдэх үндсэн дөрвөн төрлийн судалгаанаас зөвхөн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны агуулгад хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ тухайлан дурдагдсан байна. Харин хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний хүрээнд хүний эрхийн үнэлгээ хийх зохицуулалт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд шинээр орсон нь сайшаалтай. Тэрчлэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, зардлын тооцооны хүрээнд хүний эрхийн үнэлгээ хийх, зөрчил, сөрөг нөлөөллийг бууруулахад гарах зардлын тооцоолол хийхийг шаарддаггүй хэвээр байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээнд тухайн хуулийн хэрэгжилтэд гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тогтоох ёстой боловч нийгмийн нөлөөллийн хүрээнд хүний эрхийн асуудлыг тусгайлан авч үзэхгүй байна.
- Дээрх судалгааны аргачлалыг Засгийн газраас батлах бөгөөд 2016 онд анх батлагдсан аргачлалд тусгагдсан хүний эрхийн нөлөөллийг тогтоох арга зүй нь төдийлөн оновчтой биш байна. Тухайлбал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны аргачлал дахь хүний эрхийн

нөлөөллийн үнэлгээний шалгуур асуулт нь хэт ерөнхий, уян хатан бус буюу тухайн харилцааны онцлогт тохируулан оновчлох боломжгүй байна. Тэрчлэн хүний эрхийн шалгуур асуултад хариулах удирдамж, заавар байхгүйгээс ихэвчлэн “тийм”, “үгүй” гэсэн ерөнхий байдлаар хариулах бөгөөд тайлбар, нотолгоо тусгах шаардлага тогтоогоогүй нь хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний ач холбогдлыг бууруулж байна.

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний аргачлалыг 2024 оны хуулийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлээгүй хэвээр байгаа тул хүний эрхийн нөлөөллийг үнэлэх зохицуулалт одоогоор хэрэгжиж эхлээгүй байна.
- Хууль санаачлагчдын зүгээс холбогдох судалгаа хийхгүй, эсхүл зохих ёсоор хийхгүй байгаа тохиолдол гарсаар буй нь Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон “судалгаа шинжилгээнд үндэслэх” зарчмын хэрэгжилт хангалтгүй, түүнд тавих хяналт сул байгааг илтгэж байна.
- УИХ-ын Тамгын газраас хэрэгжүүлэх хяналтын хүрээнд хуулийн төслийг суурь судалгаанд үндэслэн боловсруулсан эсэхийг хянах шаардлага Хууль тогтоомжийн тухай хуульд шинээр туссан боловч хэрэгжилт нь одоогоор тодорхойгүй байна.
- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийж буй байдлыг авч үзвэл, ихэнх тохиолдолд аргачлалд дурдсан 17 асуултаар хязгаарлагдах бөгөөд асуултад зөвхөн тийм, үгүй гэсэн байдлаар ямар нэгэн үндэслэл, нотолгоогүй өнгөц хариулт өгсөн нь нийтлэг байна.
- Хууль тогтоомжийн төслийн суурь судалгааны дүгнэлтүүд нь өөр хоорондоо зөрчилдөх, хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулахад судалгааны дүгнэлтийг харгалзан үзэхгүй байх явдал

нийтлэг байгаа нь хууль санаачлагчдын зүгээс суурь судалгаанд ач холбогдол өгөхгүй байгааг илэрхийлж байна.

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох суурь судалгааг хуулийн төсөл боловсруулахтай зэрэгцүүлэн болон дараа нь нөхөж хийж, хөндлөнгийн, хараат бус судалгааны байгууллагаар хийлгэхгүй хууль санаачлагч өөрөө хийх, ингэхдээ судалгааны дүгнэлт, зөвлөмжийг хуулийн үзэл баримтлал, агуулгад тохируулах байдал ажиглагдаж байна.
- 2023 онд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар батлагдсан хууль тогтоомжийн төсөлд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал нь агуулгын хувьд нэлээд дэвшилттэй болсон байна. Гэхдээ үүний дагуу хийгдсэн үнэлгээний мэдээллийг байгууллагын дотоод баримт бичиг гэсэн үндэслэлээр нээлттэй болгохгүй байгаагаас түүний чанар, үр дүнг үнэлэх боломжгүй байна.
- Дээрх бүх судалгааны хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх нийгмийн бүлгийг хуульд заасны дагуу бүрэн, оновчтой тодорхойлох, хуулийн төслийг тэдэнд тухайлан танилцуулж, санал шүүмж авах явдал хангалтгүй байна.
- Санал авах ажиллагааг хязгаарлагдмал хүрээнд буюу зөвхөн төрийн холбогдох байгууллагуудын хүрээнд хийдэг бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талууд болон олон нийтийн хувьд ихэнх тохиолдолд хэрхэн санал өгөх нь ойлгомжгүй, цахим хуудас ашиглан хүргүүлсэн саналыг хууль тогтоомжийн төсөлд тусгадаг эсэх нь тодорхойгүй, процессын хувьд хуулийн төслийг санал өгөх үе шат өнгөрсний дараа олон нийтэд нээлттэй болгодог зэрэг дутагдал нийтлэг байна.

## Зөвлөмж

- Хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээний хүрээнд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагыг хуульчлах,
- Монгол Улсын Засгийн газраас 2016 онд баталсан хууль тогтоомжийн төслийн судалгааны аргачлалуудыг Хууль тогтоомжийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн сайжруулах. Ялангуяа, хүний эрхийн нөлөөллийг үнэлэх шалгуур асуултуудыг нарийвчлах, тухайн хуулийн зохицуулах харилцаанаас хамааран уян хатан байдлаар хэрэглэх боломжийг бий болгох, үнэлгээний дүгнэлтийг тоо баримт, судалгаагаар нотлох шаардлага тогтоох,
- Хууль тогтоомжийн төслийн холбогдох судалгааг хөндлөнгийн, хараат бус судалгааны байгууллагаар хийлгэх шаардлагыг хуульчлах,
- Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд танилцуулах, санал авах зорилгоор цахим орчинд байршуулахдаа холбогдох судалгааны тайланг хамт нийтлэх,
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, УИХ-ын Тамгын газраас хэрэгжүүлэх хууль тогтоомжийн бүрдүүлбэрийн хяналтын хүрээнд суурь судалгааны чанарт үнэлэлт дүгнэлт өгч, судалгааны дүгнэлт зөвлөмжийг хуулийн төсөлд тусгасан байдал зэргийг шалгадаг болох. Ялангуяа, хуулийн төслийн үйлчлэлд хамаарах этгээд буюу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг оновчтой, бүрэн тодорхойлсон эсэх, тэдэнд үзүүлэх нөлөөллийг тогтоосон үндэслэл, тайлбар, нотолгоо хавсаргах, хуулийн төслийг тэдэнд тухайлан танилцуулж, санал шүүмж авсан болон саналыг хуулийн төсөлд тусгасан эсэхийг нарийвчлан шалгах удирдамж бий болгох,
- Дээрх байгууллагуудаас хийсэн хяналтын үр дүн буюу хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлтийг нээлттэй болгох, хуулийн төслийн бүрдүүлбэр хангаагүй тохиолдол, хууль зүйн дүгнэлтийн дагуу хуулийн төсөлд хийгдсэн өөрчлөлтийг мэдээлдэг болох,
- Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах аргачлалыг анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах аргачлалаас ялгаатай байдлаар зохицуулах.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Ном товхимол

- [О.Мөнхсайхан, Р.Очирбал], [2021 он], [Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл], [Улаанбаатар хот]
- [Хүний эрхийн үндэсний комисс], [2023 он], [Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл], [Улаанбаатар хот]
- [Д.Лүндээжанцан], [2016 он], [Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник], [Улаанбаатар хот]

### Хууль, журам

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 59 дүгээр тогтоол, түүний хавсралт
- Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 03 сарын 24-

ны өдрийн 187 дугаар захирамж, түүний хавсралт

- Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 05 сарын 24-ны өдрийн 77 дугаар захирамж, түүний хавсралт

### Цахим хаяг

- [www.dparliament.mn](http://www.dparliament.mn)
- [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
- [www.moc.gov.mn](http://www.moc.gov.mn)

### Хавсралтын жагсаалт

- Хавсралт 1. Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийг тодорхойлох асуулт
- Хавсралт 2. Хүний эрхийн үнэлгээний асуултад огт хариулаагүй хуулийн төслүүд
- Хавсралт 3. Хүний эрхийн үнэлгээний асуултын хариултад тайлбар, үндэслэл дурдаагүй хуулийн төслүүд



*Хавсралт 1. Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааны хүрээнд хүний эрхийн нөлөөллийг тодорхойлох асуулт*

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоог боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй
4. Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй

*Хавсралт 2. Хүний эрхийн үнэлгээний асуултад огт хариулаагүй хуулийн төслүүд*

№	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр
1	2024.03.20	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2	2024.05.06	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай
3	2024.05.01	Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
4	2024.05.12	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай
5	2024.05.12	Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
6	2023.10.31	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай

*Хавсралт 3. Хүний эрхийн үнэлгээний асуултын хариултад тайлбар, үндэслэл дурдаагүй хуулийн төслүүд*

№	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр
1	2023.06.28	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай
2	2023.10.12	Хүүхэд хамгааллын тухай хууль
3	2023.10.13	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
4	2023.10.23	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
5	2023.11.28	Тусгаар тогтнол үндэсний баялгийн сангийн тухай
6	2023.12.07	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
7	2024.01.11	Цусны донорын тухай
8	2024.03.27	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай
9	2024.04.05	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай
10	2024.04.18	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай
11	2023.01.16	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
12	2023.06.02	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай
13	2023.06.02	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
14	2024.04.09	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
15	2024.04.30	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай
16	2024.05.21	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

*Хавсралт 4. Судалгаанд хамрагдсан хуулийн төслүүд  
(2023.01.01-2024.06.30-ны хооронд өргөн мэдүүлэгдсэн)*

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
1.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.04	"Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай" Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төсөл, Зөвшилцөх	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
2.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.04	"Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай" Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төсөл, Зөвшилцөх	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
3.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.08	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	Судалгаа боловсруулагдсан.
4.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.08	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хэрэгжилтийн үр дагаврын судалгааны тайлан нийтлэгдээгүй буюу судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй.
5.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.09	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	Бүх судалгаа хийгдсэн.
6.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.09	Женев хотноо 1958 онд батлагдсан "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
7.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.09	"Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
8.	УИХ-ын гишүүн Ш. Адъяа	2023.01.10	Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
9.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.09	"Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцын 50 дугаар зүйлийн а) хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
10.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.10	Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
11.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.16	Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
12.	УИХ-ын гишүүн Г. Тэмүүлэн	2023.01.16	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд	Бүх судалгаа хийгдсэн.
13.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
14.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Ухаалаг засаг II төсөл"-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
15.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Монгол Улсын шүүхийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Судалгаа хийх шаардлагатай эсэх нь тодорхойгүй, ямар нэг судалгааны тайлан нийтлэгдээгүй
16.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хэрэгжилтийн үр дагаврын судалгааны тайлан нийтлэгдээгүй буюу судалгаа хийсэн эсэх нь тодорхойгүй.
17.	Монгол Улсын Засгийн газар	2023.01.18	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
18.	УИХ-ын гишүүн Ч. Ундрам	2023.03.20	Органик бүтээгдэхүүний тухай /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
19.	УИХ-ын гишүүн О. Цогтгэрэл	2023.04.05	Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
20.	УИХ-ын гишүүн Н. Энхболд	2023.04.06	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
21.	Монгол Улсын Засгийн газар	2023.04.15	Улс төрийн намын тухай /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
22.	Монгол Улсын Засгийн газар	2023.04.20	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
23.	Монгол Улсын Ерөнхийлөгч	2023.04.26	Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.16 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
24.	Монгол Улсын Засгийн газар	2023.04.30	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.3 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
25.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.01	Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
26.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.04	Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт	Бүх судалгаа хийгдсэн.
27.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.16	"Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр"-ийн төсөл, зөвшилцөх	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
28.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.25	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	Бүх судалгаа хийгдсэн.
29.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.25	"Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
30.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.25	"Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
31.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.25	"Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц"-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
32.	Монгол Улсын Засгийн газар	2023.05.30	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
33.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.02	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
34.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.02	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
35.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.07	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.2 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
36.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.15	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
37.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.15	Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
38.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.19	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.24 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
39.	УИХ-ын гишүүн Ж. Бат-эрдэнэ	2023.06.20	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
40.	УИХ-ын гишүүн Д. Тогтохсүрэн	2023.06.20	Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
41.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.23	Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.24 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
42.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.24	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
43.	УИХ-ын гишүүн Ш. Адъяаа	2023.06.24	Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
44.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.28	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
45.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.28	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
46.	Монгол Улсын Засгийн газар	2023.06.29	Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
47.	УИХ-ын гишүүн Ц. Мөнх-оргил	2023.07.30	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.22 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
48.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.01	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.2 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
49.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.01	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.2 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
50.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.01	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.2 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
51.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.01	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.3 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
52.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.03	"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
53.	УИХ-ын гишүүн Э. Бат-амгалан	2023.10.10	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
54.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.12	Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
55.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.13	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
56.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.19	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
57.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.19	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
58.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.23	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
59.	Монгол Улсын Засгийн газар	2023.10.31	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
60.	Монгол Улсын Засгийн газар	2023.11.03	Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
61.	Монгол Улсын Засгийн газар	2023.11.03	Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг зөвшилцөх	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
62.	Монгол Улсын Засгийн газар	2023.11.22	Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
63.	Монгол Улсын Засгийн газар	2023.11.28	Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын "Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
64.	Монгол Улсын Засгийн газар	2023.11.28	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
65.	УИХ-ын гишүүн О. Цогтгэрэл	2023.11.28	"Тусгаар тогтнол үндэсний баялгийн сангийн тухай" анхдагч хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
66.	Монгол Улсын Засгийн газар	2023.11.30	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
67.	УИХ-ын гишүүн С. Одонтуяа	2023.12.07	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
68.	Монгол Улсын Засгийн газар	2023.12.20	"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
69.	Монгол Улсын Засгийн газар	2023.12.20	"Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
70.	Монгол Улсын Засгийн газар	2023.12.21	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
71.	УИХ-ын гишүүн Ш. Адъяшаа	2023.12.27	Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
72.	УИХ-ын гишүүн Ш. Адъяшаа	2024.01.03	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
73.	Монгол Улсын Ерөнхийлөгч	2024.01.04	Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.16 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
74.	Монгол Улсын Засгийн газар	2024.01.08	Төмөр замын тээврийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.-
75.	Монгол Улсын Засгийн газар	2024.01.08	Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
76.	Монгол Улсын Засгийн газар	2024.01.10	Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
77.	Монгол Улсын Засгийн газар	2024.01.11	Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
78.	УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн	2024.01.11	Цусны донорын тухай	Бүх судалгаа хийгдсэн.
79.	УИХ-ын гишүүн Б. Баярсайхан	2024.01.15	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
80.	УИХ-ын гишүүн Б. Баттөмөр	2024.02.06	Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
81.	УИХ-ын гишүүн Ц. Мөнх-Оргил	2024.03.05	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулга	Бүх судалгаа хийгдсэн.
82.	УИХ-ын гишүүн Ц. Мөнх-Оргил	2024.03.05	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
83.	Монгол Улсын Засгийн газар	2024.03.17	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
84.	УИХ-ын гишүүн Т. Энхтүвшин	2024.03.20	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
85.	УИХ-ын гишүүн Ж. Батжаргал	2024.03.27	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
86.	УИХ-ын гишүүн Ц. Цэрэнпунцаг	2024.04.02	Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
87.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.02	Үндэсний баялгийн сангийн тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
88.	УИХ-ын гишүүн Н. Энхболд	2024.04.05	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай /шинэчилсэн найруулга/	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.22 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
89.	УИХ-ын гишүүн Н. Энхболд	2024.04.05	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай /Шинэчилсэн найруулга/	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.22 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
90.	УИХ-ын гишүүн Н. Энхболд	2024.04.05	Монгол Улсын Их Хурлын тухай /Шинэчилсэн найруулга/	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.22 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
91.	УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар	2024.04.05	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.



№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
92.	УИХ-ын гишүүн С. Одонтуяа	2024.04.09	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
93.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.10	Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.17 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
94.	УИХ-ын гишүүн Б. Пүрэвдорж	2024.04.10	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
95.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.11	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	Бүх судалгаа хийгдсэн.
96.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.11	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	Бүх судалгаа хийгдсэн.
97.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.14	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
98.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.16	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай / Шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
99.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.16	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
100.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.17	Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
101.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.17	Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа нийтлэгдээгүй буюу судалгаа хийгдсэн эсэх нь тодорхойгүй.
102.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.18	Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
103.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.18	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
104.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.18	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
105.	УИХ-ын гишүүн Г. Тэмүүлэн	2024.04.18	Малчны тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
106.	УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн	2024.04.18	Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
107.	УИХ-ын гишүүн Г. Тэмүүлэн	2024.04.21	Малчны тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай	Бүх судалгаа хийгдсэн.
108.	Монгол Улсын Ерөнхийлөгч	2024.04.21	Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.16 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
109.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.21	Төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг болон олон улсын бусад гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх асуудлаар олон улсад хамтран ажиллах тухай Любляна-Гаагийн конвенцын төслийг зөвшилцөх тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
110.	УИХ-ын гишүүн С. Одонтуяа	2024.04.25	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
111.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.29	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.3 дахь заалтын дагуу судалгаа шаардахгүй.
112.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.29	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа нийтлэгдээгүй буюу судалгаа хийгдсэн эсэх нь тодорхойгүй.
113.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.30	Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Европын конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
114.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.30	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
115.	Монгол Улсын Засгийн газар	2024.04.30	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
116.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.01	Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай	Бүх судалгаа хийгдсэн.
117.	УИХ-ын гишүүн Н. Энхболд	2024.05.01	Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
118.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.02	"Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц"-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
119.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.02	Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль / Шинэчилсэн найруулга/-ийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
120.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.06	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай /Анхдагч хуулийн төсөл/	Бүх судалгаа хийгдсэн.
121.	Монгол Улсын Ерөнхийлөгч	2024.05.12	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
122.	Монгол Улсын Ерөнхийлөгч	2024.05.12	Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
123.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.14	Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд	Бүх судалгаа хийгдсэн.
124.	УИХ-ын гишүүн Д. Цогтбаатар	2024.05.19	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
125.	УИХ-ын гишүүн Г.Ганболд	2024.05.19	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
126.	УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн	2024.05.21	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.

№	Өргөн мэдүүлсэн этгээд	Өргөн мэдүүлсэн огноо	Хуулийн төслийн нэр	Холбогдох судалгаа хийсэн, тайланг нийтэлсэн эсэх
127.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.23	Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
128.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.23	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
129.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.23	Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай /Шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
130.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.27	Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын XV хавсралтыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
131.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.27	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай /шинэчилсэн найруулга/	Бүх судалгаа хийгдсэн.
132.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.28	Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА /Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн/-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтын дагуу судалгаа шаардахгүй.
133.	Монгол Улсын Засгийн газар	2024.05.29	Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Бүх судалгаа хийгдсэн.
134.	УИХ-ын гишүүн С. Бямбацогт	2024.06.02	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Бүх судалгаа хийгдсэн.
135.	Монгол Улсын Засгийн газар	2024.06.02	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай	Бүх судалгаа хийгдсэн.

**БАГИЙН АХЛАГЧ Л.АМГАЛАНБААТАР, ХУУЛЬЧ (LL.M), СУДЛААЧ**



2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг бакалавр, 2020 онд Япон Улсын Нагояагийн их сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэйгээр

төгссөн ба 2020 оноос хойш Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хуульч, өмгөөлөгчөөр тус тус ажиллаж байна.

**Х. НОРОВСҮРЭН, ХУУЛЬЧ (LL.B), СУДЛААЧ**



МУИС-ийн Хууль зүйн сургуулийг 2021 онд төгссөн ба компанид хуулийн зөвлөх болон Хүний эрхийг хангах үндэсний

хороонд ажилласан туршлагатай, одоогоор УИХ-ын Тамгын газарт ажиллаж байна.

**Б. ЖАВХЛАН, ХУУЛЬЧ (LL.B), СУДЛААЧ**



Хүний эрхийг хамгаалах залуу хуульчдын клуб НҮТББ-ын судлаач, хуульч, өмгөөлөгч. 2021 онд МУИС-ийн

Хууль зүйн сургуулийг бакалавр зэрэгтэй төгсөөд Өмгөөллийн Ананд Адвокатс ХХН-д ажиллаж байсан туршлагатай.

**ЗӨВЛӨХ:** Д.Эрдэнэчимэг, ННФ-ын засаглалын хөтөлбөрийн менежер